



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.7 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний аргачлал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар, ажлын хэсгийн ажиллах хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн боловсруулахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Мөнхбат/-д даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Хатанбаатар/-д үүрэг болгосугай.

САЙД



Н.УДВАЛ

001381



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Мөнхбат ЭМЯ, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Нарийн бичгийн дарга

Н.Цогзолмаа ЭМЯ, Бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

С.Эвлэгсүрэн ЭМЯ, НЭМХ-ийн дарга

А.Жаргал ЭМЯ, Химийн бодисын аюулгүй байдал, эмнэлгийн гаралтай хог хаягдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Ш.Уранцэцэг ЭМЯ, Орчны эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Л.Дуламсүрэн, ЭМЯ, Салбар хоорондын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

С.Өнөрсайхан, НЭМҮТ-ийн хор судлалын секторын эрхлэгч

Х.Шүрэнцэцэг, НЭМҮТ-ийн Эрүүл ахуй, хүний экологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан

Одонцэцэг Браун, Пакт Институт ОУБ-ын суурин төлөөлөгч, Эрүүл Мэндийн Бодлогыг Дэмжих Сан ТББ-ын Тэргүүн

Б.Говьгэрэл, НЭМҮТ-ийн хор судлалын секторын эрдэм шинжилгээний ажилтан

Г.Эрдэнэбаясгалан, БОНХЯ-ын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Э.Эрдэнэчимэг, ЭМШУИС-ийн НЭМС-ийн багш /зөвшилцсөнөөр/

Пүрэвдорж, ЭМШУИС-ийн НЭМС-ийн багш /зөвшилцсөнөөр/

Д.Нарансүх ЭМШУИС-ийн НЭМС-ийн багш
/зөвшилцсөнөөр/

Д.Баярболд МХЕГ-ын ЭМХХ-ийн дарга
/зөвшилцсөнөөр/

Б.Баясгалан МХЕГ-ын ЭМХХ-ийн ЭАХХХ-ын улсын
ахлах байцаагч /зөвшилцсөнөөр/

З.Мөнхтуул МХЕГ-ын хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын
байцаагч /зөвшилцсөнөөр/

Ц.Содномпил, АХБ-ны зөвлөх /зөвшилцсөнөөр/

Л.Оюун, "Тэргүүн судлаач" ТББ-ын тэргүүн
/зөвшилцсөнөөр/

Д.Сүхгэрэл, "Оюу Толгойн Хяналт" ТББ-ын гүйцэтгэх
захирал /зөвшилцсөнөөр/



Эрүүл мэндийн сайдын 2013 оны 19-р сарын 19-өдрийн 131 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Үндэслэл: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.7 дахь заалтыг хэрэгжүүлэх

Зорилго: Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний аргачлал боловсруулан батлуулах

Үйл ажиллагааны чиглэл:

- Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний анхдагч төслийг үндэсний зөвлөх авч боловсруулах
- Боловсрогдсон төслийг ажлын хэсгийн уулзалтаар хэлэлцэх
- Ажлын хэсгээс эцэслэсэн Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний төсөлд салбар хоорондын хэлэлцүүлэх уулзалтыг зохион байгуулах
- Төсөлд яамны газар, хэлтэс болон мэргэжлийн салбар зөвлөл, хэрэгжүүлэгч, хамтрагч талуудаас санал авах
- Төсөлд саналыг тусган, эцэслэн боловсруулах

Хугацаа: 2013 оны 5 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 1

Хамтран ажиллах байгууллагууд: ЭМЯ, НЭМҮТ, МХЕГ, АХБ, ДЭМБ, ТББ-ууд

Санхүүжүүлэгч: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний аргачлал боловсрогдоно.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 04
сарын 19 өдрийн 13 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа /сар/								
		4	5	6	7	8	9	10	11	
1	Ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулах									
2	Аргачлалын төслийн анхдагч төсөл бэлэн болох									
3	Төслийг хэлэлцэх уулзалт зохион байгуулах									
4	Төслийг дахин ажлын хэсгээр боловсруулах: Хэлэлцүүлгийн үр дүн, гарсан саналыг тусгах									
5	Төслийг салбар хоорондын уулзалтаар хэлэлцүүлэх									
6	Салбар хоорондын уулзалтаар хэлэлцүүлсэн үр дүнг тусгасан төслийн эцсийн хувилбарыг бэлэн болгох									
7	Төслийг БОНХЯ-нд хүргүүлэх									
8	Батлагдсан аргачлалыг үнэлээчдэд танилцуулах уулзалт зохион байгуулах									